



**ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР**



ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

***ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
САНАМЖ БИЧИГ***

2014 оны 09 дүгээр
сарын 26 -ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар болон Тахарын ерөнхий газар /цаашид “Талууд” гэх/ Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах, харилцан мэдээлэл солилцох ажлыг шуурхай болгоход энэхүү санамж бичгийн зорилт оршино.

1.2 Шүүгч, улсын ялагч, гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, Монгол Улсын олон улсын гэрээний заалтын дагуу ялтан шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх, зорчигчийн хил нэвтрэлтийн талаар мэдээлэл солилцох ажиллагааг зохион байгуулахад энэхүү санамж бичгийг мөрдөнө.

Хоёр.Талуудын эрх үүрэг

2.1 Оргон зайлсан яллагдагч, ялтны улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамж, Тахарын ерөнхий газрын Мөрдөн шалгах, эрэн сурвалжлах газрын дарга эсхүл түүнийг орлох эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулсан албан бичгийг тус газрын Эрэн сурвалжлах хэлтэс /цаашид “Эрэн сурвалжлах хэлтэс” гэх/ нь Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газар /цаашид “Шалган нэвтрүүлэх газар” гэх /-т нэн даруй ирүүлнэ.

2.2 Эрэн сурвалжлах хэлтсээс ирүүлэх албан бичигт улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх зорчигчийн паспортад кирилл, латин үсгээр бичигдсэн овог, эцгийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, паспортын болон регистрийн дугаар зэргийг алдаагүй үнэн зөв тусгана. Албан бичигт алдаатай болон буруу мэдээлэл тусгаснаас тухайн иргэн улсын хил нэвтэрсэн бол Тахарын ерөнхий газар хариуцна.

2.3 Шалган нэвтрүүлэх газар улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх шүүгчийн захирамж, албан бичгийг үндэслэн тухайн иргэнийг улсын хилээр үл нэвтрүүлэх иргэдийн жагсаалтад бүртгэнэ.

2.4 Тухайн иргэнийг улсын хилээр гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгохтой холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон, таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож

шийдвэрлэсэн бол Эрэн сурвалжлах хэлтэс нь энэ талаарх албан бичиг, шүүгчийн захирамжийг Шалган нэвтрүүлэх газарт нэн даруй ирүүлнэ.

2.5 Эрэн сурвалжлагдаж байгаа иргэн улсын хилээр гарахыг завдсан тохиолдолд Шалган нэвтрүүлэх газар тухайн иргэнийг түр саатуулан нэн даруй Эрэн сурвалжлах хэлтэст мэдэгдэнэ.

2.6 Эрэн сурвалжлах хэлтэс нь зорчигчийн улсын хил нэвтрэлтийн талаарх мэдээллийг шуурхай авах зорилгоор холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын иргэний бүртгэл, паспортын хяналтын нэгдсэн сүлжээ /цаашид “цахим сүлжээ” гэх/-г ашиглаж болно. Тахарын ерөнхий газар нь цахим сүлжээнд холбогдоход шаардлагатай техникийн нөхцөл тогтоох, харилцан холболт, угсралт, суурилуулалт хийх, сувгийн түрээсийн гарах зардлыг бүрэн хариуцна.

2.7 Талууд харилцан солилцох мэдээ, мэдээлэл, баримт бичиг болон хувийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгална. Дээр дурдсан мэдээллийг санамж бичигт зааснаас өөрөөр ашиглах эсвэл гуравдагч этгээдэд дамжуулах нөхцөлд нөгөө Талаас урьдчилан зөвшөөрөл авна.

Гурав. Талуудын хамтын ажиллагаа

3.1 Эрэн сурвалжлах хэлтсээс ирүүлсэн албан бичиг, шүүгчийн захирамжийг үндэслэн зорчигчийн улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Шалган нэвтрүүлэх газар шуурхай шийдвэрлэнэ.

3.2 Шалган нэвтрүүлэх газар, Эрэн сурвалжлах хэлтэс нь холбоо барих албан хаагчийн утас, хаягийг албан бичгээр солилцоно.

3.3 Санамж бичгээр хүлээсэн тус тусын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа асуудлыг тухай бүр Удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулж, хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.4 Нийтээр амрах баярын өдрүүд болон ажлын бус цагаар, эсхүл цаг алдалгүй улсын хилээр гарахыг түдгэлзүүлэх /оргон зайлж болзошгүй онц хүнд гэмт хэрэгтэн гэх мэт/ зайлшгүй шаардлагатай тохиолдолд Тахарын ерөнхий газрын харьяа тойргийн Тахарын алба нь яаралтай арга хэмжээг авахуулахаар Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын орон нутаг дахь Газрын даргад мэдэгдэж, Шалган нэвтрүүлэх хэлтэст холбогдох материалаа хүргүүлж, зөвхөн тухайн харьяа боомтын чиглэлд түр хориг тавих арга хэмжээг шийдвэрлүүлнэ.

3.5 Энэхүү санамж бичгийн зорилгыг хэрэгжүүлэх явцад гарч болох аливаа асуудлаар Талууд бололцоотой дэмжлэг тусламжийг харилцан үзүүлнэ.

Дөрөв. Гадаад улсаас ялтан шилжүүлэн авах, гадаад улсад ялтан шилжүүлэх ажиллагаа

4.1 Тахарын алба нь эрх бүхий байгууллагаас ялтан солилцох шийдвэр гарсан даруйд Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт мэдэгдэнэ. Тухайн иргэний паспорт буюу паспортыг орлох баримт бичиг, холбогдох бусад материалыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт ялтан шилжүүлэх ажиллагааг зохион байгуулахаас ажлын 7 өдрөөс доошгүй хугацааны өмнө шилжүүлнэ.

4.2 Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11-т заасныг үндэслэн тухайн

иргэний паспорт болон түүнийг орлох баримт бичигт Монгол Улсад орох эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарласан тэмдэг дарж, бүртгэл, хасалт хийж, Тахарын ерөнхий газарт шилжүүлнэ.

4.3 Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар нь Монгол Улсын хилээр Тахарын албаны алба хаагч, ялтан нэвтрэх үед холбогдох хууль тогтоомжийн дагуу үзлэг, шалгалтыг хийн нэвтрүүлнэ.

4.4 Тахарын албанаас ялтан шилжүүлэх ажиллагаа явагдах хилийн боомтыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт урьдчилан мэдэгдэнэ.

Тав. Бусад

5.1 Талууд улсын хилээр үл нэвтрүүлэх иргэдийн нэрсийн жагсаалтад улирал тутам тулгалт хийнэ.

5.2 Хамтын ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, мэдээллийг хагас, бүтэн жилээр гаргаж, хоёр байгууллагын удирдлагад танилцуулна.

5.3 Талуудын хамтын ажиллагааны үр дүнг үндэслэн байгууллага, албан хаагчдыг урамшуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж болно.

5.4 Энэхүү санамж бичгийг зөрчсөн албан хаагчдын талаарх мэдээллийг талууд харилцан солилцож, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Санамж бичиг хүчин төгөлдөр болох, нэмэлт өөрчлөлт оруулах

6.1 Талуудын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн “Санамж бичиг” нь хүчин төгөлдөр болно.

6.2 “Санамж бичиг”-т нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон харилцааг талууд санал нэгдэсний үндсэн дээр шийдвэрлэнэ.

**ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫГ**

ТӨЛӨӨЛЖ

ДАРГА

Б.ПҮРЭВДОРЖ

**ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ ТЭРГҮҮН ТАХАР**

ДАРГА

Ц.АЗБАЯР